



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 19 нэрийн, нийт 38,896,432.16 (гучин найман сая найман зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун гучин хоёр төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 39,467,932.30 (гучин есөн сая дөрвөн зуун жаран долоон мянга есөн зуун гучин хоёр төгрөг гучин мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Архангай, Говь-Алтай, Өвөрхангай аймаг дахь Мал эмнэлгийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны “Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох тухай” 600 дугаар тогтоолын хавсралтын Өвөрхангай аймаг дахь Мал эмнэлгийн газрын 20 дугаар мөр, 813 дугаар тогтоолын хавсралтын 93, 98, 102, 103, 110, 147, 153-158, 160-162, 164, 182, 256, 264 дугаар мөрийг хүчингүйд тооцсугай;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АШИГЛАЛТЫН ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

		Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох хугацаа (жил)	Цаашид шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
АРХАНГАЙ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР								
1	Ширээний компьютер иж бүрдэл	2019.12.30	2	1,169,000.00	2,338,000.00	2	1,402,800.00	2,805,600.00
2	Сэнстэй ууршуулагч	2012.09.28	2	1,451,250.00	2,902,500.00	5	1,741,500.00	3,483,000.00
3	Принтер хэвлэгч	2020-12-31	3	220,000.00	660,000.00	3	594,000.00	1,782,000.00
4	Махны РН метр	2020-12-31	2	1,750,000.00	3,500,000.00	3	2,100,000.00	4,200,000.00
5	компьютер / ДЕЛИ цахир /	2012.12.24	3	820,000.00	2,460,000.00	3	2,214,000.00	6,642,000.00
6	Таблет	2020-12-31	3	825,000.00	2,475,000.00	3	2,227,500.00	6,682,500.00
7	Ажлын ширээ	2012.12.25	2	320,000.00	640,000.00	2	192,000.00	384,000.00
8	Сейф шилэн нүүртэй	2012.12.25	2	350,000.00	700,000.00	2	210,000.00	420,000.00
9	Шилэн нүүртэй шкаф /цахир /	2012.12.25	2	380,000.00	760,000.00	3	228,000.00	456,000.00
10	Хувцасны шкаф / цахир /	2012.12.25	2	420,000.00	840,000.00	3	252,000.00	504,000.00
11	Ширээ 2 нүдтэй	2003.02.01	3	180,900.00	542,700.00	5	162,810.00	488,430.00
12	Ширээ 1 нүдтэй	2005.01.01	4	178,680.00	714,720.00	5	214,416.00	857,664.00
13	Ширээ нүдгүй	2000.05.06	4	144,720.00	578,880.00	5	173,664.00	694,656.00
14	Сейф төмөр	1998.01.01	2	90,450.00	180,900.00	3	54,270.00	108,540.00

15	Шүүгээ номын	2007.12.31	2	200,651.08	401,302.16	2	120,390.65	240,781.30
16	Сандал,	2001.12.10	9	54,270.00	488,430.00	3	146,529.00	1,318,761.00
	Дүн		47	8,554,921.08	20,182,432.16		12,033,879.65	31,067,932.30
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР								
17	Принтер	2019-11-30	1	500,000.00	500,000.00	2	200,000.00	200,000.00
	Дүн		1	500,000.00	500,000.00	2	200,000.00	200,000.00
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР								
18	Dell optiflex 3060 MT i3	2019-10-18	6	1,501,500.00	9,009,000.00	2	600,000.00	3,600,000.00
	Маханд антибиотекийн үлдэгдэл тодорхойлох багаж	2020-10-30	3	3,000,000.00	9,000,000.00	3	1,500,000.00	4,500,000.00
	Дүн		9	4,501,500.00	18,009,000.00	5	2,100,000.00	8,100,000.00
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР								
19	Уулзалтын ширээ	2008.12.31	1	205,000.00	205,000.00	3	100,000.00	100,000.00
	Дүн		1	205,000.00	205,000.00	3	100,000.00	100,000.00
	НИЙТ ДҮН		58	13,761,421.08	38,896,432.16		14,433,879.65	39,467,932.30
				(гучин найман сая ерэн зургаан мянга дөрвөн зуун гучин хоёр төгрөг арван зургаан мөнгө)	(гучин есөн сая дөрвөн зуун жаран долоон мянга есөн зуун гучин хоёр төгрөг гучин мөнгө)			